



Хүүхдийн

хэл 6

сартайгаас

6 сартай хүүхдийн хэл ярианы талаар

- Таны хүүхдэд дэлхий дээр олж мэдэх зүйл их байна! Хүүхдээ юу харж байгааг мэдээд, тэрэнд нь зориулж үг хэлээрэй. Том, жижиг, сонирхолтой бүхнийг хамтдаа олж мэд!
- Таны хүүхэд нүүрний илрэл, дуу авиа, хөдөлгөөн ашиглан одооноос эхлэн тантай ярьж байна. Удахгүй хүүхэд бас *да-да, та-та* гэх мэт үгтэй төстэй авиагаар шулганаж эхэлнэ.
- Таны хүүхэд яваандаа *ээж, аав, хар даа* мэт үг хэллэгийг ойлгож эхэлнэ.
- Таны хүүхэд тантай ярилцах, нуугдаж тоглох, *маамуу нааш ир-ийг* дуулах зэргээр энгийн хөдөлгөөнт тоглоомд дуртай болно.

Бүх зүйлийн талаар ярилц

Болж буй зүйл болон хүүхдийн сонирхсон бүх зүйлийн талаар хүүхэдтэйгээ ярилц. Хоол, хувцас, харж байгаа болон хүүхдийн хийж байгаа юмны талаар ярилц. Хүүхдийг идэвхтэй сонс, тэгвэл хүүхэд яриагаа үргэлжлүүлэхийг хүснэ. Түүнд хангалттай хугацаа өг!

Өөрчлөөд, дахин хий

Хүүхдийн гаргасан авиаг давтаж, ямар утгатай болохыг нь тааж, үг оноо. Дараа нь хүүхэд авиа, хөдөлгөөнөөр хариулахыг нь хүлээж байж үргэлжлүүл. Хүүхэд одооноос эхлэн ээлжлэн ярихыг сурч, үг, эд зүйлийн хоорондын уялдаа холбоог ойлгож эхэлнэ.

Хэл ярианы тоглоом

Дуу дуул, мөр холбо, дууны тоглоом тогло. Гар, хөлийн хуруу ашигла, шүгэлд, хүнгэнэ, хошигно! Таны номын санд зээлээр авах ном, дуу, хөгжим бий.

Хамтдаа уншихын зэрэгцээ яр

Харц болон заах чиглэлийг тань дагаж эхлэх үед хүүхдэд зурагтай ном нь сонирхолтой шинэ танил болно. Зураг руу зааж, юу вэ гэдгийг ярьж өг. Хүүхэд юу сонирхож байгааг анхаар. Эхэндээ түүний сонирхол богино байх ч яваандаа анхаарлаа төвлөрүүлэх чадвар нь сайжирна.


Төрөлх хэлээрээ ярь

Төрөлх хэлээрээ ярь, дуул, унш. Дэлхий дээрх олон хүүхэд олон хэлтэй орчинд амьдардаг бөгөөд нэгээс олон хэлтэй өсөх нь зөвхөн сайн талтай.

Нэмэлт мэдээлэл авах

- Номын эхлэл буюу Bokstart-ын талаар дэлгэрэнгүй эндээс уншина уу: www.bokstart.se
- Хэрэв та хүүхдийнхээ хэл ярианы хөгжилд санаа зовж байгаа бол хүүхдийнхээ эрүүл мэндийн төвд хандаарай. Мөн та хүүхдийнхээ хэл ярианы хөгжлийн талаар цэцэрлэгийн ажилтнуудтай ярилцаж болно.

Соёлын хороо нь ном уншихыг сурталчлах болон бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих үүрэг даалгаврыг засгийн газраас авч ажиллаж байна. Номын эхлэл нь эцэг эх, хүүхдийн дэргэдэх насанд хүрэгчдэд чиглэсэн үндэсний хэмжээний санаачлага юм.



ХҮҮХДИЙН НЭЛ 1 наснаас

1 настай хүүхдийн хэл ярианы талаар

- Хүүхэд дохио зангаа, дуу авиа ашиглан танд ямар нэг зүйлийг хэлнэ.
- Эхний үгс нь яг тэнд байгаа зүйлтэй холбоотой буюу бөмбөг, бамбарууш, хар даа гэх мэт байна.
- Хүүхэд илэрхийлж чадахаасаа илүү үг ойлгодог ч, юмыг ойлгох, хариулт өгөхөд түүнд таны тусламж хэрэгтэй.

Хүүхдийн сонирхлыг дага

Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэхийн тулд өдөр тутмынха амьдралд харагдаж буй эсвэл хийж буй зүйлээ ашиглаж болно. Хүүхэд яг одоо юунд анхаарал хандуулж байна, яг тэрэнд нь үг оноо. Хүүхэд муур руу заагаад *даа* гэвэл та ингэж хариулж болно: *Тийм ээ, энэ бол муур. Чи мууранд дуртай юу?* Дараа нь хүүхдийн хариултыг хүлээхээ мартуузай.

Анхаарал тавь, сонс

Хэрэв та хүүхдэд бүх анхаарлаа хандуулж түүнийг анхааралтай сонсвол, хэлснийг нь чухал гэж бодож байгааг тэр мэдэрнэ, тэгээд хүүхэд үг хэлнэ, юм руу заана эсвэл өөр аргаар харилцана. Таны хариултаас тэр ээлжлэн ярьдаг гэдгийг сурна.

Хэл ярианы тоглоом

Дуу дуул, шүлэглэ, унш, дууны тоглоом тогло. Гар, хөлийн хуруу ашигла, шүгэлд, хүнгэнэ, хошигно!

Түүх зохиож ярь

Хүүхдийн бамбарууш юу хийж байгаа, гадаа автобус хаашаа явж байгааг ярь. Хамаатан садан, найз нөхдийнхөө зургийн талаар ярь. Хүүхэд шинэ үгсийг өөр өөр нөхцөлд, олон удаа сонсох хэрэгтэй.

Зурагтай ном унш

Одоо та нар зурагтай ном ашиглаж болно. Зургуудыг хараад, зураг руу хамтдаа заа. Эхлээд та өөрөө ярьж өгөх нь дээр, харин яваандаа хүүхэд уншсаныг сонсож чадна. Таны номын санд ямар ном зээлэх тухай зөвлөмж бий.


Төрөлх хэлээрээ ярь

Төрөлх хэлээрээ ярь, дуул, унш. Дэлхий дээрх олон хүүхэд олон хэлтэй орчинд амьдардаг бөгөөд нэгээс олон хэлтэй өсөх нь зөвхөн сайн талтай.

Нэмэлт мэдээлэл авах

- Номын эхлэл буюу Bokstart-ын талаар дэлгэрэнгүй эндээс уншина уу: www.bokstart.se
- Хэрэв та хүүхдийнхээ хэл ярианы хөгжилд санаа зовж байгаа бол хүүхдийнхээ эрүүл мэндийн төвд хандаарай. Мөн та хүүхдийнхээ хэл ярианы хөгжлийн талаар цэцэрлэгийн ажилтнуудтай ярилцаж болно.

Соёлын хороо нь ном уншихыг сурталчлах болон бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих үүрэг даалгаврыг засгийн газраас авч ажиллаж байна. Номын эхлэл нь эцэг эх, хүүхдийн дэргэдэх насанд хүрэгчдэд чиглэсэн үндэсний хэмжээний санаачлага юм.



Хүүхдийн хэл 18 сартайгаас

18 сартай хүүхдийн хэл ярианы талаар

- Энэ насны олон хүүхэд өдөр тутмын хэрэглээний 200 орчим үг ойлгоно.
- Хүүхэд өөрөө зарим үг ашиглах ч, түүний үг өөр өөр нөхцөлд өөр өөр утгатай байж болно.
- Зарим хүүхэд үг нийлүүлж *ээж машин, нохой тэнд* гэх мэт хэлж эхэлнэ.

Бие биетэйгээ их ярилц

Юу хийж байгаагаа тухайн орчин, нөхцөлд нь ярь. Хүүхдэд юу болж байгааг, та нар юу хийж байгааг үгээр илэрхийл. Хүүхэд юу бодож, мэдэрч байгааг анхааралтай чагна. Хүүхэддээ хангалттай хугацаа өг.

Хүүхдийн хэлснийг давтаж, сайжруул

Хүүхдийн өөрийнх нь үгийг хэрэглэж, дээр нь шинийг нэмэх хүүхдийн хэл яриаг хөгжилд сайн. Хэрвээ хүүхэд “нямням” гэвэл та: *Тийм ээ, хоолны цаг боллоо, одоо бид идэх гэж байна* гэж хэлж болно. Таны хүүхэд энэ насанд *муур* биш *мууй* гэж хэлэх нь цөөнгүй. Хүүхдийг тэр болгонд засах хэрэггүй, харин муур гэдэг үгийг өөрөө хэл, тэгвэл хүүхэд хэрхэн зөв хэлэхийг сонсоно.

Хүүхдийн ертөнцтэй холбо

Шинэ зүйл сурахад нь хүүхдийн аль хэдийн мэддэг зүйлтэй нь холбож хэлж өгвөл сайн. Номонд өмдний зураг харвал хүүхдийн өөрийнх нь өмд рүү заагаад: *Чи ч гэсэн номон дээрх хүүхэд шиг өмдтэй байна* гэж хэлж болно.

Хамтдаа уншихын зэрэгцээ ярь

Хүүхэд одоо тантай ярих дуртай олон номтой болж байна. Номонд юу болж байгаа тухай олон сонголттой асуулт асууж, хүүхдийн өөрийнх нь туршлагатай холбо: *Чи юу гэж бодож байна ...? Чи ... санаж байна уу?*


Төрөлх хэлээрээ ярь

Төрөлх хэлээрээ ярь, дуул, унш. Дэлхий дээрх олон хүүхэд олон хэлтэй орчинд амьдардаг бөгөөд нэгээс олон хэлтэй өсөх нь зөвхөн сайн талтай.

Нэмэлт мэдээлэл авах

- Номын эхлэл буюу Bokstart-ын талаар дэлгэрэнгүй эндээс уншина уу: www.bokstart.se
- Хэрэв та хүүхдийнхээ хэл ярианы хөгжилд санаа зовж байгаа бол хүүхдийнхээ эрүүл мэндийн төвд хандаарай. Мөн та хүүхдийнхээ хэл ярианы хөгжлийн талаар цэцэрлэгийн ажилтнуудтай ярилцаж болно.

Соёлын хороо нь ном уншихыг сурталчлах болон бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих үүрэг даалгаврыг засгийн газраас авч ажиллаж байна. Номын эхлэл нь эцэг эх, хүүхдийн дэргэдэх насанд хүрэгчдэд чиглэсэн үндэсний хэмжээний санаачлага юм.



ХҮҮХДИЙН ХЭЛ 3 наснаас

3 настай хүүхдийн хэлний талаар

- Энэ насны олон хүүхэд хэдэн зуун үг ойлгоно. Тэд үгсээр өгүүлбэр зохиож, богино яриа өрнүүлж эхэлнэ.
- Хүүхэд олон асуулт асууж, үг хэрхэн ашиглах, үгээр туршилт хийж болохыг ойлгож эхэлнэ.
- Таны хүүхэд өөрийн хийсэн зүйлсийг ярьж эхэлж, ярихыг тань сонсох дуртай болно.

Үсэг, үгс ол

Цэцэрлэгийн насны олон хүүхэд үсэг, үг сонирхоно. Хүүхэд сонирхож байвал пайз, сав баглаа руу зааж, унш. Мөн эргэн тойронд байгаа тэмдгүүдийг хамтдаа олж, ямар утгатайг ярилц.

Шинэ үг тайлбарла

Өдөр тутамд болж байгаа, харж байгаа зүйлээ шинэ үгээр дүрсэл. Хүүхэд ойлгохгүй байгаа үгийг тайлбарла: *далай бол нэг төрлийн том нуур.*

Эсвэл: *эрэг рүү очоод далайд сэлье.*

Ярилц

Өдрийн явцад юу болсон тухай ярилц. Хүүхдийн цэцэрлэгтэй юу хийснийг нь та сонссон эсвэл харсан бол тэр тухай нь асууж, нэмж яриул.

Ихэнх гурван настай хүүхэд бүх үгийг насанд хүрэгч шиг хэлэхгүй. Хүүхэд үгийг өөрөөр хэлэхийг сонсвол зөв хэлж өг, тэгвэл хүүхэд яваандаа зөв хэлнэ.

Хамтдаа унш

Өдөр бүр бага зэрэг уншиж хэвш. Олон хүүхэд дахин дахин унших дуртай номтой байдаг. Зургийн номууд өнөө үед арай илүү текст агуулж болох ч, уншихын зэрэгцээ ярих нь чухал хэвээр.

Ном юуны тухай өгүүлж байгаа тухай яриа өдөөж, хүүхэд асуулт тавихыг дэмж. Хүүхэд асуулт тавихад яриагаа зогсоож, сонсоод, дараа нь хамтдаа бод.

Тоглоом бол хүүхдийн сурах арга зам гэдгийг сана. Тиймээс хамтдаа тоглож, уншиж, дуулж, ярь. Шүлэг, дуу түүнд хөгжилтэй хэвээр байна. Ном унших нь шинэ үг сурах хамгийн сайн арга!

Төрөлх хэлээрээ ярь

Төрөлх хэлээрээ ярь, дуул, унш. Дэлхий дээрх олон хүүхэд олон хэлтэй орчинд амьдардаг бөгөөд нэгээс олон хэлтэй өсөх нь зөвхөн сайн талтай.

Нэмэлт мэдээлэл авах

- Номын эхлэл буюу Bokstart-ын талаар дэлгэрэнгүй эндээс уншина уу: www.bokstart.se
- Хэрэв та хүүхдийнхээ хэл ярианы хөгжилд санаа зовж байгаа бол хүүхдийнхээ эрүүл мэндийн төвд хандаарай. Мөн та хүүхдийнхээ хэл ярианы хөгжлийн талаар цэцэрлэгийн ажилтнуудтай ярилцаж болно.

Соёлын хороо нь ном уншихыг сурталчлах болон бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих үүрэг даалгаврыг засгийн газраас авч ажиллаж байна. Номын эхлэл нь эцэг эх, хүүхдийн дэргэдэх насанд хүрэгчдэд чиглэсэн үндэсний хэмжээний санаачлага юм.